



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 17 өдөр

Дугаар A/418

Хэрлэн сум

Үер уснаас урьдчилан сэргийлэх  
арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Шадар сайдын баталсан “Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх” нэгдсэн арга хэмжээ, “Үер усны ослоос үрсээ хамгаалъя” аяныг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагаанд 1,700,000 ( нэг сая долоон зуун мянган) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засагчарын Тамгын газрын  
2022 оны 07 дугаар сарын 17-ны  
17 дугаар албан бичгийн хавсралт

Зардлын гооцоо

д/д	Байгууллагын нэр	Хийгдэх ажил	Үнэ
1	Онцгой байдлын газар	Гол нуурын эрсдэл бүхий газруудад бүлэг томилон ажиллуулах	1,000,000
		Багц мессэж ашиглан иргэдэд сээрэмжлүүлэг хүргэх	200,000
		Гол нуурын эрсдэл бүхий газарт иргэдэд, сээрэмжлүүлэх, тэмдэг тэмдэглэгээ самбар байршуулах	500,000
Нийт			1,700,000